

Хоёр дахь ирэлтэд бэлтгэх

Ариун газруудад зогсогтун

Дараах судрын хэсгүүд болон хэлсэн үгсийг уншаад, бидний ариун газруудад зогсож болох арга замуудыг хайж ол.

Дуулал 24:3–4; Исаиа 58:13; Хиламан 5:12; 3 Нифай 18:24; Сургаал ба Гэрээ 27:15; 115:5–6

Залуу эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн Анн М.Дибб эгч ийн тайлбарлажээ.



Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон “Ариун газрууд гэдэгт манай ариун сүмүүд, ариун ёслолын танхим, гэр орон, гадаснууд ордог бөгөөд эдгээр нь . . . ‘хамгаалалт, хоргодох байр болдог’ [Сургаал ба Гэрээ 115:6] гэж зөвлөсөн байдаг” [“Prepare Yourself for the Great Day of the Lord,” *New Era*, May 1982, 50]. Эдгээрээс гадна бид илүү олон ариун газрыг олж чадна гэдэгт би итгэдэг. Газар гэдэг үгийг тунгаан бодоход хамгийн эхлээд бодит газар юм уу газарзүйн байрлал бидний санаанд орж болох юм. Гэвч толь бичигт газар гэдэг үгийг ‘ялгаатай нөхцөл байдал, байршил эсвэл оюун санааны төлөв байдал’ хэмээн тодорхойлсон байна [Merriam-Webster Online, “place,” merriam-webster.com/dictionary/place]. Үүнээс харахад ариун газрууд нь Ариун Сүнсний бидэнд гэрчилсэн мөн Тэнгэрлэг Эцэгийнхээ хайрыг мэдэрсэн болон бидний залбирлуудад хариулсан мөчүүд байж болно. Үүнээс илүүгээр, таны зөв зүйлийн төлөө зоригтойгоор зогсож чадах тэр мөч, ялангуяа танаас өөр хэн ч үүнийг хийхийг хүсэхгүй тийм нөхцөлд та нар ариун газруудыг бий болгож байдаг гэдэгт би итгэдэг. (Анн М.Диб, “Таны ариун газрууд,” 2013 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 115)

Ариун Сүнсийг зам заагчаа болго

Дараах судрын хэсгүүд болон мэдэгдлүүдийг уншаад, Ариун Сүнсийг зам заагчаа болгож болох арга замуудыг хайж ол.

Сургаалт үгс 3:5–6; Дуулал 118:8–9; 1 Нифай 4:6; 2 Нифай 32:5; Моронай 10:5; Сургаал ба Гэрээ 11:12–14

Тэргүүн зөвлөлийн ерөнхийлөгч Даллин Х.Өүкс ийн заасан.



Бид хэрхэн Ариун Сүнсийг зам заагчаа болгох вэ? Бид долоо хоног бүр нүглээ наманчилж; цэвэр гар, ариун зүрхтэйгээр ариун ёслолоос хүртэхээр зарлиглуулсны адилаар [Сургаал ба Гэрээ 59:8–9, 12] ийн үйлдэх ёстой. Гагцхүү энэ арга замаар бид “[өөрсөдтэйгөө] үргэлж Түүний Сүнсийг хамт байлгах болно” (Сургаал ба Гэрээ 20:77) гэсэн тэнгэрлэг амлалтыг хүлээн авч чадна.

. . . Бид үргэлж тэрхүү Сүнсийг авч үлдэхэд шаардлагатай зүйлсийг хийдэг байх ёстой.

Бид зарлигуудыг сахиж, удирдамжийн төлөө залбиран, сүмд явж, ням гараг бүр ариун ёслолоос хүртэж байх ёстой. Мөн бид Сүнсийг холдуулах юуг ч хэзээ ч хийх ёсгүй. Ялангуяа порнограф, архи, тамхи, мансууруулах бодисоос, түүнчлэн ариун явдлын хуулийг зөрчихөөс бид зайлсхийх ёстой. (Dallin H. Oaks, “Be Not Deceived,” *Liahona*, Nov. 2004, 46)